



ТӨВ АЙМАГ
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/40

Бүрэн сум

Халдварт шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх угаалга хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 (а) дахь заалт, 29.2 дахь хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын халдварт шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх угаалгын ажлыг 2021 оны 07 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 2021 оны 08 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд хийж дуусгах ажилд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (С.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

2. Мал бүхий иргэдтэй гэрээ хийж, угаалга хийж дуусгах ажлыг зохион байгуулж, өрхийн дэвтэрт хөтлөлт хийж, баталгаажуулах ажлыг Түмий, Баясгалан-Уул, Сайн Цохио, Арцат Баянгүн, Баялагсүрэг Баянтөхөм Хариуцлагатай Хувьцаат Компанийн малын эмч (Д.Цэрэндаваа, Б.Дэлгэрнасан, Д.Хасбазар, Л.Сарантуяа, Д.Оюунтуяа) нарт даалгасугай.

3. Угаалгын явцад хяналт тавьж, хүн хүчний тусламж үзүүлж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.ТҮВШИНБАТ

410500173